



54

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 90

Номгон

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТ ХХК-ний өргөгч краныг
Хот тохижилт ОНӨААТҮГазарт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор-Эрчим хүч ЦТ ХХК-ний хөрөнгөд бүртгэлтэй 1 нэрийн 18 500 000 төгрөгийн өртөг бүхий өргөгч краныг Хот тохижилт ОНӨААТҮГазарт үнэ төлбөргүй шилжүүлсүгэй.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнхөд дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай:

2.1 Тухайн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг комисс томилон, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 08 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА




Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/th togtool-2019

1190093